



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/148/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улиастай сум  
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа  
Утас: 99993365  
Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)  
Аудитын менежер: Х.Болдбаатар  
Утас: 99105506  
Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)  
Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор:  
Б.Цэрэндэжид  
Утас: 99812811  
Цахим хаяг: [tserendejid1109@gmail.com](mailto:tserendejid1109@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, тогилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Удистай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-36-12

И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 49

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 онд Улсын төсвөөс 434,054.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 71,409.4 мянган төгрөгийн санхүүжилттэй, 62,473.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, өглөг, авлага үүсгээгүй ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 9 нэр төрлийн 9,144.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгөтэй, цэцэрлэгийн хүүхдийн хоолыг нормативт зардлаас 279.1 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

#### Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 онд төсвийн хөрөнгөөр 2,365.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 28,660.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, сумын 100 жилийн ойн хандиваар 42,615.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгажээ.

D/disk/Албан бичиг/Дүгнэлт-2025

812529083

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *[Signature]* Д. БАТ-УНДРАА  
УЛСЫН СЕКТОРЫН  
НЯГТЛАН БОДОХ  
БҮРТГЭЛИЙН  
ОЛОН УЛСЫН  
СТАНДАРТЫН  
ДАГУУ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Баянхайрхан сумын хүүхдийн  
цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152,792,233.39	276,398,353.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	94,964,442.08	200,833,922.89
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	94,964,442.08	200,833,922.89
3121	Төгрөг	94,964,442.08	200,833,922.89
31211	Төрийн сангийн харилцах	94,964,442.08	200,833,922.89
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	96,953.12	
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	96,953.12	
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	57,730,838.19	75,564,430.80
351	Түүхий эд материал	29,563,082.19	33,188,982.19
3511	Тусгай зориулалттай материал	28,459,582.19	32,298,982.19
3513	Эм боох материал	1,103,500.00	890,000.00
353	Бэлэн бүтээгдэхүүн		7,524,905.61
354	Хангамжийн материал	28,167,756.00	34,850,543.00
3541	Бичиг хэргийн материал	567,640.00	491,670.00
3542	Аж ахуйн материал	269,300.00	1,312,020.00
3544	Түлш, шатах тослох материал		855,770.00
3545	Барилгын засварын материал	1,364,500.00	
3546	Хүнсний материал	8,881,016.00	8,078,478.00
3547	Бусад хангамжийн материал	17,085,300.00	24,112,605.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,750,222,984.33	2,864,812,288.77
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,750,222,984.33	2,864,812,288.77
392	Биет хөрөнгө	2,682,571,109.33	2,797,332,288.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,767,375,921.57	2,767,375,921.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	-261,024,433.86	-309,007,098.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл		15,600,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	163,488,756.79	370,929,426.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,325,845.55	-111,978,095.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,686,589.46	73,977,589.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,945,714.43	-36,857,461.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,300,000.00	25,070,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,462,499.76	-10,179,062.22
39217	Ном	6,478,335.11	12,401,068.59
393	Биет бус хөрөнгө	67,651,875.00	67,480,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,478,125.00	-1,650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	67,480,000.00	67,480,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,903,015,217.72	3,141,210,642.46
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		84,153,248.00

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		84,153,248.00
413	Өглөг		84,153,248.00
4136	Бусад өглөг		84,153,248.00
41361	Байгууллагад төлөх өглөг		84,153,248.00
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,903,015,217.72	3,057,057,394.46
51	Засгийн газрын хувь оролцоо	2,903,015,217.72	3,057,057,394.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	227,667,451.60	227,667,451.60
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн	227,667,451.60	227,667,451.60
512	Хуримтлагдсан үр дүн	2,481,904,889.75	2,635,947,066.49
5121	Өмнөх үеийн үр дүн	2,481,904,889.75	2,481,904,889.75
5122	Тайлант үеийн үр дүн		154,042,176.74
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	193,442,876.37	193,442,876.37
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,903,015,217.72	3,141,210,642.46

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Байгууллагын нэр: Баянхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	390,218,994.93	585,985,467.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,370,494.93	80,521,167.61
120	Нийтлэг татварын бус орлого	13,370,494.93	80,521,167.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,370,494.93	
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос		
1200041	санхүүжих	100,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,270,494.93	
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		71,275,167.61
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		9,246,000.00
120018			
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	376,848,500.00	505,464,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	365,622,300.00	434,054,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	365,622,300.00	434,054,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,226,200.00	71,409,400.00
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		
132001	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	11,226,200.00	71,409,400.00
1340	санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	328,613,390.35	539,081,645.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,613,390.35	539,081,645.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	327,094,383.12	496,565,521.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,883,122.34	338,266,542.00

210101	Үндсэн цалин	168,625,810.34	218,145,036.00
210102	Нэмэгдэл	50,996,040.00	106,510,526.00
210104	Урамшуулал	11,261,272.00	13,610,980.00
	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх</b>		
2102	шимтгэл	28,847,995.89	42,563,505.03
210201	Тэтгэврийн даатгал	19,625,065.86	28,930,124.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,308,831.23	3,308,525.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,847,065.00	1,907,026.57
210204	Ажилгүйдлийн даатгал	449,366.70	1,652,034.99
210205	Эрүүл мэндийн даатгал	4,617,667.10	6,765,793.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,322,892.77	29,874,515.63
210301	Гэрэл, цахилгаан	248,744.77	352,650.63
210302	Түлш, халаалт	3,956,948.00	29,258,165.00
210303	Цэвэр, бохир ус	117,200.00	263,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,145,008.00	3,319,440.00
210401	Бичиг хэрэг	127,300.00	335,580.00
210402	Тээвэр, шатахуун	950,100.00	1,268,360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,448,400.00	1,715,500.00
210408	Бараа материал акталсны зардал	1,619,208.00	
2105	Нормативт зардал	33,406,118.00	40,076,070.00
210502	Хоол, хүнс	33,406,118.00	40,076,070.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,969,300.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,969,300.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний		
2108	төлбөр, хураамж	566,400.00	429,240.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	566,400.00	429,240.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,953,546.12	40,036,208.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,918,900.00	3,179,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,139,300.00	4,280,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,895,346.12	32,576,258.53
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,519,007.23	42,516,124.37
2132	Бусад урсгал шилжүүлэг		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,519,007.23	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,519,007.23	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		42,516,124.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		42,516,124.37
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Дотоод эх үүсвэрээр		
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	61,605,604.58	46,903,822.05
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.2	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.2	
IV	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-0.2	
V	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	61,605,604.38	46,903,822.05

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	365,722,300.00	434,054,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	365,622,300.00	434,054,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	365,622,300.00	434,054,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	365,622,300.00	434,054,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	304,672,365.46	430,985,487.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,672,365.46	430,985,487.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	303,153,358.23	430,985,487.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,883,122.34	338,266,542.00
210101	Үндсэн цалин	166,681,395.80	218,145,036.00
210102	Нэмэгдэл	53,200,854.54	106,510,526.00
210104	Урамшуулал	11,000,872.00	13,610,980.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,847,995.89	42,563,505.03
210201	Тэтгэврийн даатгал	19,625,065.86	28,984,063.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,308,831.23	3,370,736.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,847,065.00	1,757,382.33
210204	Ажилгүйдлийн даатгал	449,366.70	1,675,335.01
210205	Эрүүл мэндийн даатгал	4,617,667.10	6,775,987.94
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	34,247,540.00	38,824,900.00
210502	Хоол, хүнс	34,247,540.00	38,824,900.00
2107	Томилголт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	653,600.00	641,440.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	653,600.00	641,440.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,521,100.00	10,689,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,560,300.00	6,705,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,960,800.00	3,983,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,519,007.23	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,519,007.23	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,519,007.23	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	61,049,934.54	3,069,412.97
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,959,600.00	2,365,300.00
	Дотоод эк үүсвэрээр	1,959,600.00	2,365,300.00
222001	Тоног төхөөрөмж	1,959,600.00	2,365,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,959,600.00	-2,365,300.00

145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	60,609,341.77	704,112.97
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,159,961.00	61,769,302.77
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	61,769,302.77	62,473,415.74

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Байгууллагын нэр: Баянхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

### ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49,446,214.00	16,538,742.17	89,958,488.83	155,943,445.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
8	.....				
9	.....				
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49,446,214.00	16,538,742.17	89,958,488.83	155,943,445.00
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			46,903,822.05	46,903,822.05
18	.....				

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Байгууллагын нэр: Баянхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	567,233,500.00	504,760,187.03	62,473,312.97	88.99

21	УРСГАЛ ЗАРДАЛ БАРАА, АЖИЛ	567,233,500.00	502,394,887.03	64,838,612.97	88.57
210	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ Цалин хөлс болон	567,233,500.00	459,878,762.66	107,354,737.34	81.07
2101	нэмэгдэл урамшил	392,976,100.00	338,266,542.00	54,709,558.00	86.08
210101	Үндсэн цалин	265,934,800.00	218,145,036.00	47,789,764.00	82.03
210102	Нэмэгдэл	119,268,300.00	106,510,526.00	12,757,774.00	89.3
210104	Урамшуулал Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,773,000.00	13,610,980.00	-5,837,980.00	175.11
2102	Тэтгэврийн даатгал	46,284,700.00	42,563,505.03	3,721,194.97	91.96
210201	Тэтгэмжийн даатгал	31,474,200.00	28,984,063.58	2,490,136.42	92.09
210202	ҮОМШӨ-ний даатгал	3,702,100.00	3,370,736.17	331,363.83	91.05
210203	Ажилгүйдлийн даатгал	1,851,400.00	1,757,382.33	94,017.67	94.92
210204	Эрүүл мэндийн даатгал	1,851,400.00	1,675,335.01	176,064.99	90.49
210205	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,405,600.00	6,775,987.94	629,612.06	91.5
2103	Гэрэл, цахилгаан	69,409,400.00	26,893,275.63	42,516,124.37	38.75
210301	Түлш, халаалт	1,265,000.00	352,650.63	912,349.37	27.88
210302	Цэвэр, бохир ус Хангамж, бараа	67,604,400.00	26,276,925.00	41,327,475.00	38.87
210303	материалын зардал	540,000.00	263,700.00	276,300.00	48.83
2104	Нормативт зардал	39,845,000.00	38,824,900.00	1,020,100.00	97.44
2105	Хоол, хүнс Эд хогшил, урсгал	39,845,000.00	38,824,900.00	1,020,100.00	97.44
2106	засварын зардал	2,000,000.00	2,000,000.00		100
210604	Урсгал засвар Томилолт, зочны зардал	2,000,000.00	2,000,000.00		100
2107	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,403,600.00	641,440.00	762,160.00	45.7
2108	Мэдээлэл, технологийн үйлчилгээ Бараа	1,403,600.00	641,440.00	762,160.00	45.7
210806	үйлчилгээний бусад зардал	15,314,700.00	10,689,100.00	4,625,600.00	69.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,330,800.00	6,705,200.00	4,625,600.00	59.18
210901	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,983,900.00	3,983,900.00		100
210902	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ Бусад урсгал шилжүүлэг		42,516,124.37	-42,516,124.37	
2113	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох Төвлөрүүлэх шилжүүлэг		42,516,124.37	-42,516,124.37	
2113403	шилжүүлэг		42,516,124.37	-42,516,124.37	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ Дотоод эх үүсвэрээр		2,365,300.00	-2,365,300.00	
222001	Тоног төхөөрөмж		2,365,300.00	-2,365,300.00	

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ					
1	ҮҮСВЭР	567,233,500.00	505,464,300.00	61,769,200.00	89.11
	УЛСЫН ТӨСВӨӨС				
131	САНХҮҮЖИХ	495,824,100.00	434,054,900.00	61,769,200.00	87.54
	Улсын төсвөөс				
131001	санхүүжих	434,054,900.00	434,054,900.00		100
	Оны эхний				
131009	үлдэгдлээс санхүүжих	61,769,200.00		61,769,200.00	
	Нэмэлт				
1311	санхүүжилтийн орлого				
	ОРОН НУТГИЙН				
132	ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	71,409,400.00	71,409,400.00		100
	Орон нутгийн				
132001	төсвөөс	71,409,400.00	71,409,400.00		100
	ТӨСВИЙН				
133	ЗАХИРАГЧДААС				
	НИЙГМИЙН				
	ДААТГАЛЫН САНГИЙН				
134	ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
	ТӨСӨВТ				
	БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ				
120004	АЖИЛЛАГААНААС				
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
	Мөнгө, түүнтэй адилтгах				
	хөрөнгийн эхний				
31	үлдэгдэл		61,769,302.77	-61,769,302.77	
	Мөнгө, түүнтэй адилтгах				
	хөрөнгийн эцсийн				
31	үлдэгдэл		62,473,415.74	-62,473,415.74	
	ТӨСВИЙН БУСАД				
1	МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
3	Төсвийн байгууллага	2	2		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.5	29.5		100
6	Удирдах ажилтан	2	2		100
7	Гүйцэтгэх ажилтан	18.5	18.5		100
8	Үйлчлэх ажилтан	9	9		100
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО	169	169		100
	(ЖИЛИЙН ДУНДЖААР)				
	СУРГУУЛИЙН				
14	ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН				
	БАЙГУУЛЛАГА		1	-1	
	Төрийн өмчит СӨБ				
15	байгууллага	2	2		100
	ОРОН ТООНЫ				
24	МЭДЭЭЛЭЛ				
	СӨБ болон бага,				
	дүнд боловсролын				
28	албан хаагч (ТҮБД)	18	18		100
	Төрийн				
	үйлчилгээний бусад				
33	албан хаагч (ТҮ)	11.5	11.5		100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Байхгүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

## **Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:**

- **Сургуулийн өмнөх боловсрол олгох**

**Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн зорилго:** Суралцагчийн эзэмших чадамж /танин мэдэхүй, эрүүл мэнд, нийгэм- сэтгэл хөдлөл/-ийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо хамтын ажиллагааг ханган хөгжүүлэх үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

*Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт:** 2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор “Хувьсах зардлыг хэмжээ, итгэлцүүр” шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан. Мөн Засгийн газрын 2024 оны 05 сарын 29-ний 237 дугаар тогтоолоор “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1,3 “Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна гэсний дагуу байгууллагын дотоод хяналтын комиссыг 2024 оны 09 сарын 02-ны А/12 тушаалаар шинэчлэн 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Журмаа шинэчлэн боловсруулж улирал бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнаж ажилладаг. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу

бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 46,903.8 мянган төгрөгөөр буюу 30.1 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	28,326.6	33,462.1	5,135.5
Үндсэн хөрөнгө	65,847.5	106,911.8	41,064.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>155,943.5</b>	<b>202,847.3</b>	<b>46,903.8</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	49,446.2	49,446.2	0.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>155,943.5</b>	<b>202,847.3</b>	<b>46,903.8</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Авлага байхгүй.

Бараа материалын эхний үлдэгдэл 28,326.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 50,713.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ойн хандивын хүрээнд 9,246.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 54,823.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 33,462.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,135.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 2365.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, сумын ойн хандивын хүрээнд 42615.0 мянган төгрөг, яамны хөрөнгө оруулалтаар 28,600.2 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 171,580.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 32,575.3 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 46,903.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 371,790.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 165,425.7 мянган төгрөг, нийт зарлагыг 537,216.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид

хүргүүлсэн байна. Төрийн албаны албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ болон нэмэгдлүүд шинэчлэн тогтоогдсоноор төсөв тодотголоор нэмж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 434,054.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 71,409.4 мянган төгрөгний санхүүжилт авч, өмнөх оны үлдэгдлээс 61,769.2 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 504,760.2 мянган төгрөг буюу 94.0 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ 58,430.8 мянган төгрөг, хоол 1,020.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4,625.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
<b>71801</b>	<b>Сургуулийн өмнөх боловсрол</b>				
80233	Хүүхэд хамгаалал	636.6	636.6	0.0	100%
81605	Эрүүл мэндийг дэмжих	1,311.2	993.0	318.2	75,7%
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	39,152.0	38,131.9	1,020.1	97.4%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,923.0	1,923.0	-	100%
81823	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	880.8	0.0	880.8	0%
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	6,261.8	5,960.8	301.0	95.2%
81834	Боловсролын стандарт сургалтын орчин	438,166.8	378,213.6	59,953.2	86.3%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	7,491.7	7,491.7	0.0	100%
<b>Орон нутгийн төсвөөс</b>					
80109	ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардал	71,409.4	28,893.3	42,516.1	40.5%
<b>НИЙТ</b>		<b>567,233.3</b>	<b>462,243.9</b>	<b>104,989.4</b>	<b>81.5%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

#### Байхгүй

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авалтыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 539,081.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,086.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,064.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно..

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд зөвлөмж өгөөгүй, акт албан шаардлага аваагүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 279.1 мянган төгрөгийн алдаа зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа:**

Байхгүй

**Шийдвэрлэсэн байдал:** Байхгүй

#### **5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй**

#### **5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

#### **5.3 Зөвлөмж**

**Илэрсэн алдаа:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 9 төрлийн 9,144.7 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

- **Илэрсэн алдаа:** Хүүхдийн хоолыг нормативт зардлаас 279.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.
- **Шийдвэрлэсэн байдал:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.




АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:



Огноо: 2025-01-26

АИДАНС 9999376  
С-1105008

БЮЛЭГ  
Х.БОЛДБААТАР  
Д.БАТ-УНДРАА

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР

Огноо: 2025-01-26

Б.ЦЭРЭНДЭХИД